ХҮ.1.1.72	21 дүгээр цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/	2008-2009	150.0	105.0
ХҮ.1.1.73	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Өмнөговь, Булган/	2007-2009	260.5	130.5
ХҮ.1.1.74	Цэцэрлэгийн барилга, 60 ор /Өмнөговь, Ноён/	2008-2010	395.9	100.0
ХҮ.1.1.75	Цэцэрлэгийн барилга, 90 ор /Өмнөговь, Номгон/	2008-2009	377.1	277.1
ХҮ.1.1.76	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Өмнөговь, Хүрмэн/	2008-2010	396.2	100.0
ХҮ.1.1.77	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Архангай, Эрдэнэбулган, 5 дугаар баг/	2008-2009	290.8	100.8
ХҮ.1.1.78	Цэцэрлэгийн барилгын дуусгал /Улаанбаатар, Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Балзуур дүүрэг, 4 дүгээр хороо/	2008-2010	453.1	229.5
ХҮ.1.1.79	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Архангай, Цэцэрлэг/	2008-2009	262.9	42.9
ХҮ.1.1.80	Цэцэрлэгийн барилга, 140 ор /Дорнод, Цагаан-Овоо/	2008-2009	551.0	375.0
ХҮ.1.1.81	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай сум, Жаргалант баг/	2008-2009	550.9	450.9
ХҮ.1.1.82	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Орхон, Баян-Өндөр сум, Шанд баг /	2008-2009	598.2	450.2
ХҮ.1.1.83	2 дугаар цэцэрлэгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хужирт/	2008-2009	386.1	236.1
ХҮ.1.1.84	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Өмнөговь, Мандал-Овоо/	2008-2009	346.4	196.4
ХҮ.1.1.85	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Хушаат/	2008-2009	300.0	200.0
ХҮ.1.1.86	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Төв, Мөнгөнморьт/	2008-2009	342.8	142.8
ХҮ.1.1.87	8 дугаар цэцэрлэгийн өргөтгөл, 100 ор /Ховд, Жаргалант/	2008-2009	331.3	181.3
ХҮ.1.1.88	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Рашаант/	2008-2009	314.8	194.8



XY.1.1.89	Цэцэрлэгийн барилга /Увс, Түргэн/	2008-2009	383.5	133.5
XY.1.1.90	Цэцэрлэгийн барилга /Увс, Наранбулаг/	2008-2009	341.2	91.2
XY.1.1.91	Цэцэрлэгийн барилга /Увс, Цагаанхайрхан/	2008-2009	365.4	115.4
XY.1.1.92	2 дугаар цэцэрлэгийн Б корпусын барилгын өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн/	2008-2009	130.0	50.0
XY.1.1.93	Хөгжим бүжгийн коллежийн хичээлийн байрны барилгын өргөтгөл /Улаанбаатар/	2008-2010	4,035.2	300.0
XY.1.1.94	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга /Хэнтий, Өндөрхаан/	2008-2010	2,500.0	266.3
XY.1.1.95	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, 100 ор /Булган, Булган/	2008-2009	494.6	344.6
XY.1.1.96	МУБИС-ийн сургалт, үйлдвэрлэлийн төв, сургуулийн шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2007-2010	1,285.6	300.0
XY.1.1.97	Багшийн коллежийн барилга /Архангай/	2008-2010	2,800.0	500.0
XY.1.1.98	Боловсрол, соёлын газрын барилга /Төв/	2008-2009	463.2	163.2
XY.1.1.99	Сургуулийн барилга, 320 суудал /Завхан, Түдэвтэй/	2009-2010	890.9	270.0
XU.1.1.100	Сургуулийн барилга, 960 суудал /Хэнтий, Биндэр/	2009-2010	1,530.0	270.0
XY.1.1.101	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, 150 ор /Улаанбаатар/	2009-2010	1,080.0	270.0
XY.1.2	Их засвар:		6,064.6	6,064.6
XY.1.2.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг дэмжих хөрөнгө оруулалт /Барилгуудын их засвар/	2009	1,000.0	1,000.0
XY.1.2.2	Аймгийн боловсрол, соёлын газрын барилгын их засвар /Говьсүмбэр/	2009	25.0	25.0
XY.1.2.3	ХААИС-ийн Мал эмнэлэг, биотехнологи, Эдийн засаг, бизнес, Экологи, технологи хөгжлийн, Инженерийн, Газар тариалангийн машин механизм, технологийн сургуулийн хичээлийн байрны барилгын, оюутны 3, 4 дүгээр байрны барилгын дээврийн их засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2009	350.0	350.0
XY.1.2.4	ХААИС-ийн Ховд аймаг дахь Алтайн бүсийн салбар сургуулийн оюутны дотуур байрны барилгын их засвар	2009	129.6	129.6
XY.1.2.5	ЕБС-ийдын хичээлийн байрны засвар	2009	3,000.0	3,000.0
XY.1.2.6	ЕБС-ийдын дотуур байрны засвар	2009	1,000.0	1,000.0
XY.1.2.7	ЕБС-ийдын спортын заалны засвар	2009	160.0	160.0
XY.1.2.8	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын их засвар	2009	400.0	400.0
XY.1.3.	Тоног төхөөрөмж:		1,237.4	1,237.4
XY.1.3.1	ЕБС-ийдын хичээлийн байрны тоног төхөөрөмж	2009	1,000.0	1,000.0
XY.1.3.2	ЕБС-ийдын дотуур байрны тоног төхөөрөмж	2009	112.4	112.4
XY.1.3.3	ЕБС-ийдын спортын заалны тоног төхөөрөмж	2009	25.0	25.0
XY.1.3.4	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын тоног төхөөрөмж	2009	100.0	100.0
XY.2	Соёл		19,250.6	9,772.3
XY.2.1	Хөрөнгө оруулалт:		18,550.6	9,072.3
XY.2.1.1	Соёлын төвийн барилга /Увс, Өндөрхангай/	2008-2010	693.7	325.0
XY.2.1.2	Соёлын төвийн барилга /Увс, Баруунтуруун/	2008-2010	602.8	325.0
XY.2.1.3	Соёл амралтын хүрээлэн /Төв, Лүн/	2008-2009	500.0	350.0
XY.2.1.4	Соёлын өвийн шинэчлэл /Хэнтий, Өмнөдэлгэр, Балданбэрэээн/	2008-2010	675.2	425.2
XY.2.1.5	Соёлын төвийн барилга, 250 суудал /Төв, Заамар/	2008-2009	523.5	223.5
XY.2.1.6	Богд хааны ордон музейн сан хөмрөгийн барилга /Улаанбаатар/	2008-2009	500.0	500.0
XY.2.1.7	Соёлын төвийн өргөтгөл, 250 суудал /Увс, Өлгий/	2008-2009	376.7	276.7
XY.2.1.8	Түүх, дурсгал, соёлын өвийг дэмжих хөрөнгө оруулалт	2008-2010	2,500.0	1,000.0
XY.2.1.9	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Баян-Өндөр/	2008-2009	138.5	88.5
XY.2.1.10	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Дарви/	2008-2009	296.5	146.5
XY.2.1.11	Соёлын төвийн барилга /Өмнөговь, Цогт-Овоо/	2008-2009	486.0	338.0
XY.2.1.12	Соёл, спортын төвийн барилга /Өмнөговь, Мандал-Овоо/	2008-2009	393.8	293.8
XY.2.1.13	Соёлын төвийн барилгын дуусгал /Хэнтий, Баян-Овоо/	2008-2009	116.9	56.9
XY.2.1.14	Соёлын төвийн барилга /Архангай, Хотонт, Өндөрсант/	2008-2009	39.9	39.9
XY.2.1.15	Соёлын төвийн барилга /Хөвсгөл, Улаан-Уул/	2008-2009	500.0	500.0

ХҮ.2.1.16	Спортын заал, 12х24м, соёлын төвийн барилга, 200 суудал /Төв, Баян/	2007-2009	425.0	75.0
ХҮ.2.1.17	Соёлын төвийн барилга, 200 суудал /Төв, Алтанбулаг/	2008-2009	227.4	77.4
ХҮ.2.1.18	Соёлын төвийн барилга, 250 суудал /Ховд, Зэрэг/	2008-2009	340.0	240.0
ХҮ.2.1.19	Соёлын төвийн барилга, 250 суудал /Ховд, Алтай/	2008-2009	389.5	289.5
ХҮ.2.1.20	Соёлын төвийн барилга, 250 суудал /Ховд, Эрдэнэбүрэн/	2008-2009	350.0	290.0
ХҮ.2.1.21	Хөөмийн ордон-Соёлын төвийн барилга, 250 суудал /Ховд, Чандмань/	2008-2009	350.0	290.0
ХҮ.2.1.22	Номын өргөөний барилгын дуусгал /Баянхонгор/	2007-2009	1,098.2	275.2
ХҮ.2.1.23	Хөгжимт драмын "Саран хөхөө" театрын барилга /Дорноговь/	2008-2009	988.2	693.2
ХҮ.2.1.24	"Алтай" чуулгын байр /Говь-Алтай/	2008-2009	1,850.0	850.0
ХҮ.2.1.25	Театр, концертын заал /Дорнод/	2008-2010	3,030.8	700.0
ХҮ.2.1.26	Аймгийн музейн барилгын шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн/	2007-2009	424.0	211.0
ХҮ.2.1.27	Соёлын төвийн шинэ барилга /Баянхонгор, Баянбулаг/	2008-2009	224.0	84.0
ХҮ.2.1.28	Соёл, спортын төв /Хэнтий, Дэлгэрхаан/	2007-2009	224.0	88.0
ХҮ.2.1.29	Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан/	2007-2009	286.0	20.0
ХҮ.2.2	Аймгуудын соёлын төвийн барилгын их засвар	2009	200.0	200.0
ХҮ.2.3	Тоног төхөөрөмж	2009	500.0	500.0
ХҮ.3	Шинжлэх ухаан		2,199.4	1,535.4
ХҮ.3.1	Хөрөнгө оруулалт: Уламжлалт анагаах ухааны корпорацийн уламжлалт эмийн үйлдвэрийн барилга /Улаанбаатар/	2008-2010	1,164.0	500.0
ХҮ.3.2	Их засвар:		335.4	335.4
ХҮ.3.2.1	Шинжлэх ухааны салбарын барилгын их засвар	2009	300.0	300.0
ХҮ.3.2.2	Газар хөдөлөлийн станцын барилгын их засвар /Архангай/	2009	25.4	25.4
ХҮ.3.2.3	Газар хөдөлөлийн станцын барилгын их засвар /Хөвсгөл/	2009	10.0	10.0
ХҮ.3.3	Тоног төхөөрөмж: Шинжлэх ухааны салбарын байгууллагуудын тоног төхөөрөмж	2009	700.0	700.0
ХҮ.4	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД		3,923.8	2,024.9
ХҮ.4.1	Хөрөнгө оруулалт: Цэргийн албан хаагчдын 126 айлын орон сууцны барилга, 3Х-ний 089 дүгээр анги /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2008-2009	2,898.9	1,000.0
ХҮ.4.2	Тоног төхөөрөмж		1,024.9	1,024.9
ХҮ.4.2.1	Терроризмын эсрэг ажиллагаанд оролцох бүлгийн зэвсэг, хэрэгсэл	2009	128.0	128.0
ХҮ.4.2.2	Энхийг сахиулах болон бусад ажиллагаанд оролцох бүрэлдэхүүнийг техник хэрэгсэл, агсамжаар хангах	2009	800.0	800.0
ХҮ.4.2.3	Тусгай зориулалтын тоног төхөөрөмж	2009	96.9	96.9
ХҮ.5	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД		705.6	605.6
ХҮ.5.1	Хөрөнгө оруулалт:		705.6	605.6
ХҮ.5.1.1	Аймгийн ХХААГ-н барилга /Баянхонгор/	2008-2009	234.0	134.0
ХҮ.5.1.2	Чацаргана тариалах, чацаргана боловсруулах үйлдвэр байгуулах /Хөвсгөл, Баянзүрх, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Ханх, Хатгал, Алаг-Эрдэнэ, Мөрөн/	2008-2009	471.6	471.6
ХҮ.6	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД		4,287.0	2,577.0
ХҮ.6.1	Хөрөнгө оруулалт: Усны хайгуул судалгаа	2007-2009	1,910.0	200.0
ХҮ.6.2	Тоног төхөөрөмж:		2,377.0	2,377.0
ХҮ.6.2.1	Байгаль орчны албадын материаллаг бааз, техник хэрэгсэл	2009	200.0	200.0
ХҮ.6.2.2	Үүлэнд зориудаар нөлөөлж бороо оруулах радар, дагалдах хэрэгсэл	2009	2,177.0	2,177.0
Х.6	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД		949.9	386.0
Х.6.1	Хөрөнгө оруулалт:		899.9	336.0

XIX.1.1	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн барилгын засвар, өргөтгөл /Улаанбаатар/	2008-2009	300.0	36.1
XIX.1.2	Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтсийн нэг цэгийн үйлчилгээ бүхий конторын барилгын засвар, шинэчлэлт /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2008-2009	300.0	120.0
XIX.1.3	Ахмадын өргөө, 30 ор /Хоад/	2008-2009	299.9	179.9
XIX.2	Тоног төхөөрөмж: НХХЯам болон төв, орон нутгийн байгууллагуудын тоног төхөөрөмж.	2009	50.0	50.0
XX	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА		821.0	321.0
XX.1	Хөрөнгө оруулалт: Дүүргийн шүүхийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй/	2008-2009	821.0	321.0
XXI	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР		35.0	35.0
XXI.1	Тоног төхөөрөмж	2009	35.0	35.0
XXII	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА		384.0	384.0
XXII.1	Тоног төхөөрөмж: Тусгай зориулалтын тоног төхөөрөмж	2009	384.0	384.0
XXIII	НИИСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА		44,234.8	13,351.3
XXIII.1	Хөрөнгө оруулалт:		44,234.8	13,351.3
XXIII.1.1	Бохир усны Туул-1 коллектор, 34.9 км /Улаанбаатар/	2007-2009	11,600.0	6,545.1
XXIII.1.2	Үйлдвэрийн районы цэвэр, бохир усны шугам сүлжээ /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2008-2009	912.0	91.2
XXIII.1.3	Баруун 4 зам-зүүн 4 замын шинэчлэлт, гүүрийн хамт 3.6 км /Улаанбаатар/	2009	3,052.8	3,052.8
XXIII.1.4	Баруун 4 замаас 10 дугаар хорооллын уулзвар хүртэлх авто замын өргөтгөл шинэчлэлт 1.6 км /Улаанбаатар/	2009-2010	2,781.0	1,765.4
XXIII.1.5	Энхтайваны өргөн чөлөөнд "Ионсей" эмнэлгийн урд замд явган хүний нүхэн гарц байгуулах /Улаанбаатар/	2009	684.0	684.0
XXIII.1.6	Замын цагдаагийн газрын конторын барилгын гадна, доторхи цахилгааны шинэчлэлт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2009	77.0	77.0
XXIII.1.7	62 дугаар цэцэрлэг, 27 айлын орон сууцны гадна дулаан, ус хангамж, ариутгал татуургын шугам /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 10 дугаар хороо/	2009	88.2	88.2
XXIII.1.8	Гэр хорооллын халуун усны барилга /Улаанбаатар/	2008-2009	588.6	156.0
XXIII.1.9	Буюнт-Ухаа орон сууцны хороолол, 7 дугаар хорооллын инженерийн шугам сүлжээг шинээр байгуулах /Улаанбаатар/	2008-2009	2,000.0	156.0
XXIII.1.10	Ногоон зоорийн орчмын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээг шинээр байгуулах /Улаанбаатар/	2008-2009	2,000.0	191.0
XXIII.1.11	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	2008-2009	1,328.2	476.2
XXIII.1.12	Замын цагдаагийн урд хэсгийн зам гүүрийн шинэчлэлт	2008-2009	200.0	68.4
	НИЙТ ДҮН		716,457.9	241,752.9

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН 2009 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХОЙШЛУУЛАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/Төсвийн ерөнхийлөн захирагчаар, сая төг/

Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Хойшлуулах хөрөнгийн дүн	
I	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	127.5	127.5
I.1	Хөрөнгө оруулалт: Орон сууцны дэмжлэг	127.5	127.5
II	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	4,183.4	4,183.4
II.1	Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газар	4,183.4	4,183.4



II.1.1	Хөрөнгө оруулалт: 20 сумыг шилэн кабелид холбох /Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан/	4,183.4	4,183.4
III	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД	1,266.8	1,266.8
III.1	Чөлөөт бүс	1,266.8	1,266.8
III.1.1	"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн доторх усан хангамжийн шугам хоолой, 9 км /Сэлэнгэ, Алтанбулаг/	1,046.7	1,046.7
III.1.2	"Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн доторх гэрэлтүүлэг /Баян-Өлгий/	45.0	45.0
III.1.3	"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн хилийн хяналтын шалган нэвтрүүлэх байр, объектууд /Сэлэнгэ, Алтанбулаг/	175.1	175.1
IV	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	1,600.0	500.0
IV.1	Хөрөнгө оруулалт: Аймгийн ЗДТГ-ын барилга /Дорнод/	1,600.0	500.0
Y	САНГИЙН САЙД	2,250.0	2,250.0
Y.1	Гаалийн ерөнхий газар	2,250.0	2,250.0
Y.1.1	Ачааны терминалын зам талбай, агуулахын өргөтгөл /Дорноговь, Замын Үүд/	2,250.0	2,250.0
YI	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	16,161.5	1,531.5
YI.1	Цагдаагийн ерөнхий газар	7,530.0	1,000.0
YI.1.1	Хөрөнгө оруулалт: Орон нутгийн сумдын төлөөлөгчийн байр	7,530.0	1,000.0
YI.2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	31.5	31.5
YI.2.1	Цэвэр бохир усыг төвийн сүлжээнд холбох угсралтын ажил, 401 дүгээр анги /Улаанбаатар/	31.5	31.5
YI.3	Үндэсний архивын газар	8,600.0	500.0
YI.3.1	Хөрөнгө оруулалт: Конторын барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	8,600.0	500.0
YII	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	37,088.7	26,732.0
YII.1	Цахилгаан дамжуулах шугам, дэд станц	9,915.8	8,029.2
YII.1.1	Тавантолгой-Даланзадгад сумын 110 кВ-ын 98 км ЦДАШ, 35/10 кВ-ын 1х0.8 мВА-ын дэд станц /Өмнөговь/	5,000.0	4,800.0
YII.1.2	Баруун Урт-Халзан сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугамын дамжуулагч утсыг АС-95 маркийн утас болгон шинэчлэх /Сүхбаатар/	415.8	415.8
YII.1.3	Гэр хорооллын айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдэлийг сайжруулах /Улаанбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүрэг/	2,700.0	1,013.4
YII.1.4	Сумдын 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах шугамын шинэчлэлт	1,800.0	1,800.0
YII.2	Дулааны цахилгаан станц, дулааны шугам	22,942.9	14,472.8
YII.2.1	"ДЦС-II" ТӨХК-ийг түшиглэн "Дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал түлш болон хийгээр эрчим хүч үйлдвэрлэх цогцолбор" байгуулах, /Улаанбаатар/	10,600.0	10,100.0
YII.2.2	Дулааны станцтай аймгуудын дулааны шугам сүлжээг шинэчлэх /Сэлэнгэ, Дархан-Уул, Увс, Сүхбаатар/	3,450.0	1,500.0
YII.2.3	Дулааны станц /Сүхбаатар/	5,400.0	1,800.0
YII.2.4	Дулаан хангамжийн системийг хаалттай системд шилжүүлэх /Улаанбаатар, Багануур дүүрэг/	3,492.9	1,072.8
YII.3	Гадаадын зээллээр хэрэгжүүлэх төслийн дотоодын эх үүсвэр:	4,230.0	4,230.0
YII.3.1	"100000 нарны гэр хөтөлбөр"-ийн Монголын талын хөрөнгө	4,230.0	4,230.0
YIII	ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	106,369.7	22,385.8
YIII.1	Авто зам	50,355.2	3,871.1
YIII.1.1	Цэцүүх-Тосонцэнгэл чиглэлийн 80 км хатуу хучилттай авто зам	16,000.0	500.0
YIII.1.2	Улаанбаатар-Эрдэнэсангын 168.2 км хатуу хучилттай авто зам	34,355.2	3,371.1
YIII.2	Гүүр	6,245.0	1,800.0
YIII.2.1	Идэрийн голын 120 улм төмөр бетон гүүр /Хөвсгөл, Жаргалант/	2,445.0	900.0
YIII.2.2	Сэлэнгэ мөрний Цацын булангийн 253 улм төмөр бетон гүүр /Хөвсгөл, Рашаант/	3,800.0	900.0
YIII.3	Барилга, хот байгуулалт	43,128.1	10,073.3



YIII.3.1	Бүсийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	364.0	245.0
YIII.3.2	Бүсүүдийн хөгжлийн төсөл	250.0	250.0
YIII.3.3	Баянголын амны орон сууцны хорооллыг дулааны эх үүсвэртэй холбох инженерийн шугам сүлжээ, IY ээлж /Улаанбаатар/	32,472.0	3,950.0
YIII.3.4	Нийтийн зориулалттай байшингийн цахилгаан шатны шинэчлэлт, 60 ш /Улаанбаатар/	1,560.0	1,350.0
YIII.3.5	Эрдэнэт хотын 11 дүгээр хорооллын инженерийн шугам сүлжээ /Орхон/	2,040.0	1,000.0
YIII.3.6	Үерийн хамгаалалтын далан, II ээлж /Дархан-Уул, Дархан/	1,300.0	832.0
YIII.3.7	Орон сууцны компаниудын харьяанд байгаа хорооллын доторхи гадна дулаан, усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/	1,435.8	540.0
YIII.3.8	Засгийн газрын бондын хөрөнгөөр баригдах орон сууцны инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	3,600.0	1,800.0
YIII.3.9	3, 4 дүгээр хорооллын 31-ийн III коллекторын ф500-ийн бохир усны шугамын өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	106.3	106.3
YIII.4	Тээвэр	6,641.4	6,641.4
YIII.4.1	Цахилгаан тээврийн хэрэгсэл угсарч үйлдвэрлэх, 50 ш	6,300.0	6,300.0
YIII.4.2	Тээврийн хэрэгсэл ачиж зөөвөрлөх автомашин, 8 ш	341.4	341.4
IX	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	20,841.6	4,633.7
IX.1	Хявдар судлалын төвийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	3,500.0	900.0
IX.2	Эрүүл мэндийн төвийн барилга, амбулатор, 100 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	3,950.0	960.0
IX.3	Спортын ордон, 450 суудал /Сүхбаатар, Баруун-Урт/	1,600.0	800.0
IX.4	Улсын клиникийн нэгдсэн 3 дугаар эмнэлгийн өргөтгөл /Улаанбаатар/	2,527.9	1,080.0
IX.5	Уламжлалт анагаах ухааны төв, 20 ор /Хэнтий/	443.7	443.7
IX.6	Улсын клиникийн нэгдсэн 1 дүгээр эмнэлгийн өргөтгөл /Улаанбаатар/	2,520.0	180.0
IX.7	Төрөх эмнэлгийн барилга, 300 ор /Улаанбаатар/	6,300.0	270.0
X	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	12,171.4	9,877.3
X.1	Боловсрол	9,251.8	7,414.7
X.1.1	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Галт/	725.7	725.7
X.1.2	Хөгжмийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөл /Завхан/	989.0	989.0
X.1.3	"Хангай" цогцолбор сургуулийн хичээлийн байрны өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Багахангай/	460.3	460.3
X.1.4	Сургуулийн дотуур байрны барилга, 120 ор /Өмнөговь, Баяндагай/	621.4	521.4
X.1.5	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Увс, Тэс/	532.3	532.3
X.1.6	Сургуулийн дотуур байрны барилга, 150 ор, /Архангай, Хотонт/	350.0	350.0
X.1.7	Спортын заалны барилга, 12x18м, /Дорнод, Булган/	232.3	192.3
X.1.8	Спортын заалны барилга, 24x18 м /Ховд, Мөнххайрхан/	660.0	660.0
X.1.9	Спортын заалны барилга, 12x18 м /Хөвсгөл, Рашаант/	398.2	398.2
X.1.10	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо/	480.8	480.8
X.1.11	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 18 дугаар хороо/	318.0	318.0
X.1.12	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо/	318.0	318.0
X.1.13	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай сумын Чигэстэй баг/	559.7	459.7
X.1.14	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 17 дугаар хороо/	250.0	250.0
X.1.15	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4/7/ дугаар хороо/	318.0	318.0
X.1.16	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	1,530.0	261.0

X.1.17	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хэнтий, Дадал/	508.1	180.0
X.2	Соёл	2,012.6	2,012.6
X.2.1	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Бууцагаан/	460.0	460.0
X.2.2	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Баянцагаан/	600.0	600.0
X.2.3	Соёл, спортын төвийн барилга /Өмнөговь, Сэврэй/	452.6	452.6
X.2.4	Соёлын төвийн барилга, 120 суудал /Архангай, Цахир/	500.0	500.0
X.3	Шинжлэх ухаан	907.0	450.0
X.3.1	Хөрөнгө оруулалт: Сансар судлалын музей планетарийн барилга /Улаанбаатар/	907.0	450.0
XI	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	2,850.0	1,050.0
XI.1	Хөрөнгө оруулалт: Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах. /Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий/	2,850.0	1,050.0
XII	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	270.0	270.0
XII.1	Хөрөнгө оруулалт: Орон сууцны дэмжлэг, 10 аймгийн 10 прокурорт орон сууц олгох.	270.0	270.0
XIII	НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА	10,841.1	10,841.1
XIII.1.1	Их тойруугийн замын өргөтгөл 3.8 км /Баруун 4 зам- Баянбүрд-100 айл-Сэлбийн гүүр/	4,024.8	4,024.8
XIII.1.2	Сүхбаатарын гудамжны авто замын өргөтгөл шинэчлэлт, 2 км /Улаанбаатар/	1,819.8	1,819.8
XIII.1.3	Нарны замын баруун зүүн хэсгийн өргөтгөл, 3.6 км /10 дугаар хорооллын өмнөх замын уулзвараас урагш ТЗ-ын вокзал, Нарантуул төв захын урдаас Чулуун-Овоотын уулзвар хүртэлх хэсэг/ /Улаанбаатар/	2,250.0	2,250.0
XIII.1.4	Наранийн энгэрийн хогийн цэг хүртэлх авто зам, гэрэлтүүлэг, 1.2 км /Улаанбаатар/	814.5	814.5
XIII.1.5	Нийтийн зориулалттай орон сууцны бариллын дэвэрийн шинэчлэлт /Улаанбаатар/	900.0	900.0
XIII.1.6	Гэр хорооллын халуун усны барилга /Улаанбаатар/	1,032.0	1,032.0
XIV	ХӨДӨӨ, ОРОН НУТАГ	14,400.0	14,400.0
XIV.1	Улаанбаатар	5,400.0	5,400.0
XIV.2	Архангай	450.0	450.0
XIV.3	Баян-Өлгий	495.0	495.0
XIV.4	Баянхонгор	450.0	450.0
XIV.5	Булган	405.0	405.0
XIV.6	Говь-Алтай	405.0	405.0
XIV.7	Говьсүмбэр	225.0	225.0
XIV.8	Дархан-Уул	450.0	450.0
XIV.9	Дорнод	450.0	450.0
XIV.10	Дорноговь	405.0	405.0
XIV.11	Дундговь	360.0	360.0
XIV.12	Завхан	450.0	450.0
XIV.13	Өвөрхангай	495.0	495.0
XIV.14	Өмнөговь	360.0	360.0
XIV.15	Сүхбаатар	405.0	405.0
XIV.16	Сэлэнгэ	495.0	495.0
XIV.17	Төв	450.0	450.0
XIV.18	Увс	450.0	450.0
XIV.19	Хөвд	450.0	450.0
XIV.20	Хөвсгөл	495.0	495.0
XIV.21	Хэнтий	405.0	405.0
XIV.22	Орхон	450.0	450.0
	Дүн	230,421.7	100,049.1



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ нь:**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /цаашид хуулийн гэх/-ийн зарим зүйл, заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

1. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5-д заасан **"...байнга оршин суугч..."** гэж Иргэний бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, энэ хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11-д зааснаар тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тодорхой хаягт бүртгэлтэй иргэнийг хэлнэ.

2. Мөн зүйлийн 9.5-д заасан **"...эсхүл уг дүүргийн нутаг дэвсгэр дэх байгууллага, аж ахуйн нэгжид ажил хөдөлмөр эрхлэгч байна"** гэдгийг төлөөлөгч нь сонгогдсон Хурлын харьяа дүүрэгт байнга оршин суугч биш боловч түүний ажлын байр нь тухайн Хурлын харьяа дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байхыг ойлгоно.

3. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5-д заасан **"байнга оршин суугч"** -ийг иргэний үнэмлэхээр;

"уг дүүргийн нутаг дэвсгэр дэх байгууллага, аж ахуйн нэгж" -ийг Хуулийн зүгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан бүртгэх эрх бүхий байгууллагын албан ёсны баримтаар;

"тухайн байгууллага, аж ахуйн нэгжид ажил хөдөлмөр эрхлэгч" -ийг ажлын газрын үнэмлэх болон нийгмийн даатгалын дэвтэр зэргээр тус тус тодорхойлно.

4. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5-д заасны дагуу явуулсан санал хураалтаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн санал аваагүй нэр дэвшигчийг Хурлын даргад **дахин нэр дэвшүүлэхгүй.**

5. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д **"Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа тухайн Хурлын шинээр сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрснөөр дуусгавар болно"** гэж зохицуулснаас гадна хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д **"...Хурлын анхдугаар хуралдаанаар Хурлын даргыг ... сонгох"**, 23 дугаар зүйлийн 23.5-д **"Анхдугаар хуралдаанаар тухайн шатны Хурлын даргыг оролцуулан ... Хурлын тэргүүлэгчдийг ... сонгох"**, 23 дугаар зүйлийн 23.13-т **"...анхдугаар хуралдаан хуралдуулж Хурлын даргыг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг..."** шийдвэрлэх талаар тус тус заасан тул Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, Хурлын даргыг болон Тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит сонгуулийн үр дүнгээр

байгуулагдсан Хурлын анхдугаар хуралдаанаар заавал хэлэлцэж дуусгана.

Харин анхдугаар хуралдаанаас тодорхой шалтгааны улмаас бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдөөгүй Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг баталгаажуулах, түүнчлэн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан үндэслэлээр Хурлын төлөөлөгч /Хурлын дарга, тэргүүлэгч/-ийн бүрэн эрх дуусгавар болсон нөхцөлд нөхөн сонгогдсон Хурлын төлөөлөгч /Хурлын дарга, тэргүүлэгч/-ийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, сонгох болон хуулийн 32 дугаар зүйлд заасан үндэслэлээр Засаг даргыг чөлөөлсөн, огцруулсан, Засаг дарга огцорсон тохиолдолд Засаг даргад шинээр нэр дэвшүүлэх эзрэг нь бусад хуралдааны хэлэлцэх асуудалд хамаарна.

6. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 32 дугаар зүйлийн 32.1-д заасан **"...хүсэлт"**-ийг бичгээр гаргана.

7. Мөн зүйлийн 13.1.4, хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасан **"шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоол"** гэдгийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 301 дүгээр зүйлд заасны дагуу ойлгоно.

8. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д заасан **"...тухайн орон нутгаас шилжсэн..."** гэдэгт Иргэний бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар байнга оршин суугаа засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд бүрмөсөн шилжихийг ойлгох бөгөөд энэ нь мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4-т зааснаар зохих журмын дагуу хийгдсэн бүртгэлээр баталгаажсан байна.

Иргэний бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар түр буюу 180 хоногоос доош хугацаагаар шилжин суурьшсаныг тухайн орон нутгаас шилжсэн гэж үзэхгүй.

9. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 23 дугаар зүйлийн 23.7, 27 дугаар зүйлийн 27.3-т заасан **"Хурлын нийт төлөөлөгч..."** гэж иргэдийн төлөөлөгчийн Хурлын хуралдаанаас бүрэн эрх нь баталгаажсан нийт сонгогдогчдыг хэлнэ.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар бүрэн эрх нь дуусгавар болж, нөхөн сонгууль явагдаагүй тохиолдолд эрх нь дуусгавар болсон тухайн төлөөлөгчийг Хурлын нийт төлөөлөгчийн тоонд оруулан тооцохгүй.

10. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д заасан **"...хүндэтгэн үзэх шалтгаан..."** гэдэгт эрүүл мэндийн байдал, албан томилолтоор явсан, ар гэрт нь гачигдал гарсан, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан бусад гамшиг тохиолдсон зэрэг хувь хүнээс өөрөөс нь үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

Хурлын дарга хуулийн дээрх зүйлд заасныг зөрчин хуралдааныг орхин гарч, хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй нь хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

Энэ тохиолдолд хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-д зааснаар тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон аль нэг төлөөлөгч хуралдааныг удирдаж үргэлжлүүлнэ.

11. Хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.3, 26.5.4, 26.6.1, 26.6.2-т заасан "... шүүхийн шийдвэр" гэснийг "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 11-д зааснаар ойгоно.

12. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 26 дугаар зүйлийн 26.7, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.10, 30.1.11, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 31.1.8, 33 дугаар зүйлийн 33.4, 36 дугаар зүйлийн 36.2-т заасан "зөвшилцөх" гэдгийг

"Ерөнхийлөгчийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 1996 оны 6 сарын 28-ны өдрийн 216 дугаар тогтоолд заасны дагуу ойгож хэрэглэнэ.

13. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.5, 23 дугаар зүйлийн 23.4, 23.13, 26 дугаар зүйлийн 26.4, 27 дугаар зүйлийн 27.2, 27.3, 32 дугаар зүйлийн 32.3, 32.4, 32.6-д заасан хугацааг Иргэний хуулийн 8 дугаар бүлэгт заасан журмыг баримтлан тоолно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР
Л.ЛАТАРЦЭЦЭГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /цаашид хуулийн гэх/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан "тусгай зөвшөөрлөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага" гэдэгт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тусгай зөвшөөрлөөр тодорхой төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйцэтгэх явцдаа заавал дагаж мөрдвөл зохих, хууль тогтоомжоор тодорхойлсон болзол, шалгуур үзүүлэлтүүдийг хамааруулан ойгоно.

2. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан "төрийн захиргааны холбогдох төв байгууллага" гэдэгт Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан байгууллагууд хамаарна.

3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан "Казиногийн үйл ажиллагаа эрхлэх"-ийг хориглох гэдэгт мөнгө буюу түүнийг орлогч металл /токенс/ хэрэглэн тоглодог электрон хэрэгсэл, слот машин, мөн тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх зориулалтын тусгай хуванчар зоос /нил/ буюу шоо, хяэр, гэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ зэрэг казиногийн зориулалтаар өрөө, тасалгаа, тоног төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан тоглоом тоглуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж ойгоно.

4. "Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих" эрхийг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т зааснаар олгосон тул үр хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хяналт, шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам, арга хэлбэрийг удирдлага болгоно.

5. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т заасан "Тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон" гэж хуулийн 11 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлж баримт бичгийг аль нэг нь хуурамч болохыг эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар нотлогдсон байхыг хэлнэ.

6. Мөн зүйлийн 14.1.4-т заасан "удаа дараа" гэж 2 буюу түүнээс дээш зөрчсөнийг хэлэх ба "ноцтой зөрчсөн" гэдэгт тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг илтэд зөрчсөнийг улмаас нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хохирол учруулсан буюу учруулж болох байсан зэрэг нөхцөл байдлыг ойлговол зохино.

7. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.2, 15.6.3, 15.6.7-д заасан "химийн хорт болон аюултай бодис" гэдгийг Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2008 оны 6 дугаар зүйлийн 25-ны өдрийн 30 дугаар тогтоолын 13-т зааснаар ойгоно.

8. Энэ зүйлийн 15.6.5-д заасан "Хүлцэх хэмжээ" гэдгийг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д зааснаар ойгож хэрэглэнэ.

9. Мөн зүйлийн 15.6.6-д заасан "байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөөцлөлийг судалгаа шинжилгээний үндсэн дээр урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө, химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, хяналт шинжилгээний хөтөлбөр, зөвлөмж, дүгнэлт бүхий тайлан гаргах үйл ажиллагааг хэлнэ.

10. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР
Ц.СҮМБЯА



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар10

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг тус тус удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн (цаашид хууль гэх) 3 дугаар зүйлийн 3-т заасан **"эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон"** гэж сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт заасан журмын дагуу Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.-т зааснаар иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтоосон ба энэхүү шийдвэр нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлд зааснаар хуулийн хүчин төгөлдөр болсон байхыг хэлнэ.

2. Хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д заасан **"Улсын Их Хуралд суудал бүхий нам"** гэдгийг Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 48 дугаар тогтоолын 8-д зааснаар ойлгоно.

3. Мөн зүйлийн 2-т заасан **"тухайн сонгуульд нэг хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй"** гэснийг: а/Улсын Их Хуралд суудалтай намууд хуулийн 22 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгчийн сонгуульд хамтарч оролцох, эсхүл хамтарч нэр дэвшүүлэхээр гэрээ байгуулснаас бусад тохиолдолд нэг намаас дэвшүүлсэн хүний нэрийг өөр нам тухайн сонгуульд дэвшүүлэхгүй.

б/Хуулийн 21, 22 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд суудалтай нам дангаараа, эсхүл хамтарч нэр дэвшүүлсэн хүнээ мөн хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар татан гаргасан, эсхүл нэр дэвшигч өөрөө татгалзсан тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн нэр дэвшүүлэхэд татан гаргасан, татгалзсан дээрх хүний нэрийг дахин дэвшүүлэхгүй гэж тус тус ойлгоно.

4. Сонгогчдын шилжих хөдөлгөөний бүртгэлийг хуулийн 15 дугаар зүйлийн 3 дэх хэсгийн 2-т заасны дагуу сонгуулийн хэсгийн хороо хийх тул энэ заалтын **"сонгогчийг шилжүүлэх"** гэдгийг тухайн хэсгийн бүртгэлээс хасах, харин **"шинээр ирсэн сонгогчийг бүртгэх"** гэдгийг тухайн бүртгэлд сонгогчийн нэрийг нэмэх гэж тус тус ойлговол зохино.

"Шинээр ирсэн сонгогч" гэдэгт өөр хэсгээс шилжин ирж буй болон гадаад улсад амьдарч байгаад эх орондоо ирснээс бусад сонгогч хамаарахгүй.

Сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдээгүй орхигдсон, эсхүл нэр, хаяг, бусад мэдээлэл нь буруу бүртгэгдсэн сонгогчийг шинээр ирсэн сонгогч гэж үзэхгүй ба сонгуулийн хэсгийн хороо эдгээр алдаар залруулах ажиллагааг Сонгуулийн Ерөнхий хорооноос Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7.-д заасны дагуу баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдэх ёсгүй хүн бүртгэгдсэн бол түүнийг шилжүүлэх буюу бүртгэлээс хасна.

Сонгогчийг шилжүүлэх, шинээр бүртгэх ажиллагааг сонгуулийн хэсгийн хороо хуулийн 17, 18 дугаар зүйлд заасан хугацаа, журмын дагуу явуулна.

5. Хуулийн 17 дугаар зүйлийн 1-д заасан **"тухайн хэсэгт байнга буюу түр оршин суугаа"** гэснийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 3-т зааснаар ойлговол зохино.

Хуулийн энэхүү заалтыг дээр дурдсанаар ойлгож хэрэгжүүлэхдээ мөн зүйлийн 5-д заасан **"Сонгогч бүр сонгуулийн нэг хэсэгт нэрийн нэг жагсаалтад бүртгэгдэх..."** гэсэн зохицуулалтыг баримталж, тухайн сонгуульд сонгогч бүр саналаа нэг удаа өгөх боломж, нөхцлийг бүрдүүлнэ.

6. Мөн зүйлийн 3-т заасан хугацаанд үйлдэгдэж, сонгогчдод танилцах боломжтойгоор ил тавигдсан нэрийн жагсаалттай сонгогч өөрөө танилцаж, өөрийн бүртгэлийн үнэн зөв байдлыг шалгах бөгөөд хуулийн 18 дугаар зүйлийн 1-д заасан гомдлыг санал хураалтаас өмнө гаргах эрхтэй болно.

7. Сонгуулийн хэсгийн хорооны шийдвэрээр тухайн хорооны ажлын хэрэгцээнд ашиглахаар сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараахаас бусад тохиолдолд хуулийн 17 дугаар зүйлийн 6-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараахыг хориглоно.

8. Хуулийн 27 дугаар зүйлийн 5-д заасан **"дэмжлэг тусалцаа"** гэдэгт ажлаас нь чөлөө олгохоос гадна үүрэгт ажлыг нь өөр хүнд хариуцуулах, ажлаас чөлөөлөгдөөгүй тохиолдолд гүйцэтгэх ажлыг нь хөнгөлөх буюу хамтран гүйцэтгэх, туслах хүнийг томилж, шаардлагатай бол нэр дэвшигчийн ажил байдлын талаар тодорхойлолт гаргаж өгөх, тухайн албан газар, байгууллагаас ажилтнууддаа үзүүлдэг үйлчилгээ, хөнгөлөлтийг эдлүүлэх зэргээр нэр дэвшигчид сонгуульд оролцоход аятай нөлөө үзүүлэхүйц энэ хууль болон бусад хуулиар хориглоогүй ажиллагааг хамааруулан ойлгоно.

9. Хуулийн 28 дугаар зүйлийн 5-д **"шашны зам үйлийг ашиглах"**-ыг хориглохоор заасан нь сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаанд аливаа шашны сургаал, жаяг дэгийн дагуу хийгддэг бүх үйл ажиллагаанд хамаарна.

Харин нэр дэвшигч иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, тор, сүм, хийдийн хоорондын харьцаа, шашны талаарх үзэл бодол, баримтгаллын талаар өөрийн мөрийн хөтөлбөрт тусгах, эдгээр асуудлаар сонгогчидтой ярилцах зэргийг үүнд хамааруулахгүй.

Мөн хэсэгт заасан **"сонгуульд үл хамаарах ажил, үйлчилгээ"** гэдгийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 7.1.3.-т заасантай адил угтаар буюу энэ хуулиар хориглосон, эсхүл зөвшөөрөгдөөгүй бөгөөд сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаанд хамаарахгүй аливаа ажиллагааг гэж ойлгоно.

10. Хуулийн 29 дүгээр зүйлийн 2-т заасан **"нэр дэвшигчид тэгш хандах"** Засаг даргын үүрэгт, сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа явуулж буй нэр

дэвшигч бүрийг үндэс угсаа, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, намын харьяаллыг харгалзахгүйгээр ижил нөхцөлөөр хангах, сонгогчидтой хийх уулзалтыг зохион байгуулахад адил хэмжээний дэмжлэг үзүүлэх, нэр дэвшигчийн заримд нь илүү таатай нөхцөл бүрдүүлэхгүй, ялгамжтай хандахгүй байх зэргийг хамааруулана.

11. Хуулийн 34 дүгээр зүйлийн 4-т **"энэ хуульд зааснаас өөр тэмдэглэл хийсэн"**, мөн зүйлийн 5-д **"нэр дэвшигчийн нэрийн өмнө тавьсан дугаарыг засварласан"** гэж тус тус заасныг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 9.1., 9.2.-т зааснаар ойлговол зохино.

12. Хуулийн 35 дугаар зүйлийн 2-т **"22 цаг болмогц сонгуулийн хэсгийн хорооноос санал тоолох тухай мэдэгдэж, олгоогүй үлдсэн саналын хуудсыг тоолж битүүмжилсний дараа саналын хайрцгийг нээж"** гэж заасны дагуу санал авах өдрийн 22 цаг 00 минутаас хойш сонгогчдод саналын хуудас олгохгүй.

13. Хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан **"хүндэтгэн үзэх шалтгаан"** гэж гэнэтийн буюу дэвагдашгүй хүчний шинжтэй, санал хураах байр, өдрийг зайлшгүй өөрчлөхөөс өөр аргагүй онцгой нөхцөл байдлыг хэлнэ.

14. Мөн хэсгийн 3-т **"сонгогчийн санал, сонгуулийн дүнг гажуудуулахад хүргэсэн"**, 4-т **"сонгуулийн дүнд ноцтой нөлөөлсөн"** гэж тус тус заасныг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 10.2., 10.3.-т зааснаар ойлгоно.

15. Мөн хэсгийн 4-т заасан **"эрх мэдлээ хэтрүүлэх"** гэдэгт энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхийг хэлнэ.

Энэ заалтын **"хууран мэхлэх"** гэдгийг Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 3-т зааснаар ойлгоно.

16. Хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3-т **"санал хураалт хуулийн дагуу явагдаагүй"** гэдэгт сонгуулийн дүнд ноцтой нөлөөлсөн зөрчил хамаарна.

17. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 53¹ дүгээр зүйлийн 1, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 23-т зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдэд захиргааны хариуцлага ногдуулах асуудлыг болон хариуцлага ногдуулсан шийтгэвэрт гаргасан гомдлыг сум буюу сум дунд, дүүргийн шүүх тус тус хянан шийдвэрлэнэ.

Хуулийн 8 дугаар зүйлийн 3-22-т заасан захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг холбогдох сонгуулийн хороонд гаргана. Уг гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндэслэн холбогдох сонгуулийн хороод Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11-16 дугаар зүйлд зааснаар зөрчлийг хянан

шалгах ажиллагаа явуулж, захиргааны хариуцлага ногдуулах шүүхэлтэй харьяалах сум буюу сум дунд, дүүргийн шүүхэд гаргана.

Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын албан тушаалтанд сахилын шийтгэл ногдуулах тухай заасан бол уг асуудлыг Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуулиудад тус тус заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

Хөрөнгө улсын орлого болгохоор заасан бол шүүх уг арга хэмжээг захиргааны хариуцлага ногдуулах асуудалтай хамт хянан шийдвэрлэнэ.

Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэхдээ шүүх Захиргааны хариуцлагын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан нөхцөл байдлыг хянаж, зөрчил гаргасан этгээдийн гэм буруу нь нотлогдсон гэж үзвэл мөн хуулийн 18 дугаар зүйлд зааснаар захиргааны шийтгэл ногдуулах тухай шийтгэвэрт гаргана.

Хянан зөрчил гаргасан гэх этгээдийн гэм буруу тогтоогдоогүй, эсхүл мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 4-т заасан нөхцөл байгаа бол шүүгч захирамж гаргаж тухайн этгээдийг хариуцлагаас чөлөөлнө.

18. Сонгуулийн нутаг дэвсгэрийн салбар болон хэсгийн хорооны шийдвэрийн талаар сонгуулийн нутаг дэвсгэрийн хороонд, сонгуулийн нутаг дэвсгэрийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн Ерөнхий хороонд тус тус гомдол гаргах хуулийн 16 дугаар зүйлийн 8-д заасан журмыг шүүхээс гадуур үрчдчилэн шийдвэрлүүлэх хуульд заасан журам гэж үзнэ.

Энэ журмыг зөрчиж шүүхэд гаргасан гомдлыг сум буюу сум дунд, дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3.-т зааснаар хүлээн авахаас татгалзаж, гомдлыг хэрхэн мэдүүлэх талаар шүүгчийн захирамжид заана.

Мөн хэсэгт **"хуульд зааснаас бусад тохиолдолд"** гэж заасны дагуу хуулийн 18 дугаар зүйлийн 2-т зааснаар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн талаарх сонгогчийн гомдлыг шийдвэрлэсэн сонгуулийн хэсгийн хорооны шийдвэрт шүүхэд гомдол гаргавал хуулийн 16 дугаар зүйлийн 8-д заасан журмыг баримтлахгүй.

19. Хуулийн 16 дугаар зүйлийн 8, 43 дугаар зүйлд зааснаар гомдлыг шийдвэрлэсэн Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаарх гомдол, хүсэлтийг Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу Үндсэн хуулийн цэцэд гаргана.

Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулиас бусад хуулийг, Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд олгогдсон сонгох, сонгогдох эрхээс бусад эрхийг зөрчсөн талаарх гомдлыг Сонгуулийн Ерөнхий хорооны оршин байгаа дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

20. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд шүүхийн 2000 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 303 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
С.БАТДЭЛГЭР
**ТАНХИМЫН
ТЭРГҮҮН**
ЦАМАРСАЙХАН

 Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакция.

 Улсын Их Хурлын Тамгын газрын
 Хэвлэх хэсэгт хэвлэв.

 Улаанбаатар-12
 Төрийн ордон-128 тоот

 262420
 Индекс 14003

329487

Хэвлэлийн хуудас 3